



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/254

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.4 дэх хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 25.3.1 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 60.1; 64.1; 64.4 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 28 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад бүтээгдэхүүн ажил үйлчилгээний баталгаажуулалтыг схемийн дагуу явуулах нийтлэг журмыг хавсралтаар баталсугай.


2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангаж ажиллахыг Тамгын газар (Б.Эрдэнэзул), Бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын газар (В.Ганзориг)-т тус тус үүрэг болгосугай.


3. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Стандартчилал, хэмжил зүйн үндэсний зөвлөлийн 2007 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 32 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсад бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний баталгаажуулалтыг схемийн дагуу явуулах журам", Стандарт хэмжил зүйн үндэсний төвийн даргын 2008 оны 28 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтыг тус тус хүчингүй болгосугай.

4. Энэхүү журмыг 2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй

ДАРГА

Г.ГАНТӨМӨР





Монгол улсад бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний баталгаажуулалтыг схемийн дагуу явуулах нийтлэг журам

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү журмаар бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ /цаашид бүтээгдэхүүн гэх/ ний баталгаажуулалтыг схемийн дагуу явуулах ерөнхий харилцааг тогтооно.

1.2 Энэ журмын хамрах хүрээнд дараахь 2 төрлийн баталгаажуулалт зохицуулагдана.

1.2.1 Заавал баталгаажуулалт /Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 13.2 дахь заалт/

1.2.2 Сайн дурын баталгаажуулалт /Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 13.3 дахь заалт/

1.3 Энэхүү нийтлэг журмын хүрээнд итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага нь өөрийн эрх мэдлийн хүрээнд үйлдвэрлэл, нийлүүлэлт ба ашиглалтын онцлогийг харгалзсан нэгэн төрлийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний баталгаажуулалтын схемийн журам, зааврыг боловсруулж баталж хэрэглэхийг зөвшөөрнө.

1.4 Энэхүү журам нь бүтээгдэхүүний баталгаажуулалтын чиглэлээр Олон улсын Стандартчиллын байгууллага (ISO) болон Олон улсын Цахилгаан техникийн комисс (IEC)-оос боловсруулсан стандарт, арга зүйн удирдамжуудад нийцүүлсэн болно.

Хоёр. Зорилго

2.1 Тухайн бүтээгдэхүүн нь нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлын талаар холбогдох норматив техникийн баримт бичигт тогтоосон шаардлагыг бүрэн хангасныг үнэн зөв нотлох;

2.2 Хэрэглэгчийг зөв сонголт хийх, хуурамч бүтээгдэхүүнээс хамгаалах, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх.

Гурав. Норматив эш таталт

Доор дурьдсан баримт бичгийн хүчинтэй хувилбарыг ашиглана. Үүнд:

- ✓ MNS ISO/IEC 17067 Бүтээгдэхүүний баталгаажуулалтын үндсэн асуудалба бүтээгдэхүүний баталгаажуулалтын схемийн заавар;

- ✓ MNS ISO/IEC 17065 Тохирлын үнэлгээ - Бүтээгдэхүүн, үйл явц болонүйлчилгээний баталгаажуулалтын байгууллагад тавих шаардлага;
- ✓ MNS ISO/IEC TR 17026 Тохирлын үнэлгээ. Биет бүтээгдэхүүний баталгаажуулалтын схемийн загвар;
- ✓ MNS ISO/IEC 17000 Тохирлын үнэлгээ-Тайлбар толь, ерөнхий зарчим;

Дөрөв. Нэр томъёо тодорхойлолт

Энэхүү журамд заасан нэр томъёогMNS ISO/IEC 17067:2014 Бүтээгдэхүүний баталгаажуулалтын үндсэн асуудал ба бүтээгдэхүүний баталгаажуулалтын схемийн заавар;MNS ISO/IEC 17000:2005 Тохирлын үнэлгээ-Тайлбар толь, ерөнхий зарчим "Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай" хуулийн 4.1, 4.2-д заасны дагуу ашиглана.

Тав. Баталгаажуулалтын үйл явц

Тохирлын үнэлгээ /Баталгаажуулалт/- үйл явцыг хавсралт 1-д, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний баталгаажуулалтын схемийн бүрэлдэхүүнийг хавсралт 2-д, бүтээгдэхүүн, үйлчилгээ, тогтолцооны баталгаажуулалтын схемийн төрлүүдийг хавсралт 3-д тус тус үзүүлэв.

Бүтээгдэхүүний баталгаажуулалтнь дараах үндсэн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

5.1 Сонголт- Баталгаажуулалтад хамруулах тухай хүсэлт хүлээн авах, бүртгэх:

5.1.1 Аж ахуйн нэгж байгууллага нь бүтээгдэхүүнээ баталгаажуулалтад хамруулах тухай хүсэлтийг баталсан загварын дагуу гаргаж баталгаажуулалтын байгууллагад ирүүлнэ.

5.1.2 Бүтээгдэхүүнийг баталгаажуулахад шаардлагатай бүрдүүлэх материалыг хавсаргасан байна. Баталсан хүсэлтийн загвар болон хавсаргах материалын жагсаалтыг www.masm.gov.mn сайтаас авна.

5.1.3 Баталгаажуулалтын байгууллага хүсэлтийг бүрдүүлэх материалын хамт хүлээн авч, бүртгэлжүүлнэ.

5.1.4 Ирүүлсэн материалд дүн шинжилгээ хийх;
Шаардлагатай тохиолдолд нэмэлт мэдээллийг цуглуулах;
Тухайн бүтээгдэхүүнд хамаарах техникийн үзүүлэлт шаардлагыг тодорхойлох;

5.2 Тодорхойлолт–Бүтээгдэхүүний тохирлыг баримт нотолгоонд тулгуурланбаримт бичгийн дүн шинжилгээ хийх:

5.2.1 Бүтээц, бүрэлдэхүүн, үйлдвэрлэлийн технологийн хувьд хэрэглэгч /захиалагч/-д нийлүүлж буй бүтээгдэхүүнтэй ижил загварын дээжинд сорилт, шинжилгээг явуулна.

5.2.2 Баталгаажуулалтын сорилтын дээжийг баталгаажуулалтын шинжээч авна.

5.2.3 Сорилтыг тухайн бүтээгдэхүүнийг баталгаажуулахад ашигласан норматив техникийн баримт бичигт тусгагдсан үзүүлэлт шаардлагын дагуу итгэмжлэгдсэн лаборатори гүйцэтгэнэ. Сорилтын дүнгийн хуудсыг бүрдүүлэх материалд хавсаргана.

5.2.4 Баталгаажуулалтын байгууллага нь сорилтын үр дүнг хүчин төгөлдөр норматив техникийн баримт бичгээр тогтоосон шаардлагад нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийнэ.

5.2.5 Ажил, үйлчилгээ болон сорилт, шинжилгээнд хамруулах боломжгүй бүтээгдэхүүний тохирлыг үнэлэхдээ хүсэлт гаргагчаас хэрэглэгч үйлчлүүлэгчдийн дунд явуулсан санал асуулгын дүнг үндэслэл болгоно.

5.2.6 Баталгаажуулалтын хамрах хүрээнд орсон бүтээгдэхүүнд стандарт, норматив баримт бичгийн дагуу үнэлгээний хуудас бэлтгэнэ.

5.2.7 Тохирлын гэрчилгээ, аюулгүйн тэмдэг хэрэглэх гэрээ хийж, үйлчлүүлэгч байгууллагаар баталгаажуулна.

5.2.8 Хамтран гүйцэтгэх байгууллага, шинжээчийг сонгоно.

5.2.9 Схем сонгоно.

5.2.10 Тохирлын үнэлгээний удирдамж боловсруулж батлуулах зэрэг ажлуудыг гүйцэтгэнэ.

5.2.11 Баталгаажуулалтын байгууллага хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 7 хоногийн дотор хүсэлт гаргагчид тохирлын үнэлгээ явуулах эсэх шийдвэрээ мэдэгдэнэ.

5.3 Дүн шинжилгээ - Тохирлын үнэлгээний үйл ажиллагааг холбогдох объект дээр явуулахдаа баталгаажуулалтын схемийн төрлөөс хамааруулан гүйцэтгэнэ.

5.3.1 Бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээний цар хүрээ, парт цуварлаас хамааруулан баталгаажуулалтын схемийг хавсралт 3-д заасны дагуу сонгон хэрэглэнэ.

5.3.2 Батлагдсан удирдамж буюу үнэлгээний хуудсын дагуу үйлдвэрлэлийг үнэлнэ. /хэрэв энэ нь баталгаажуулалтын схемд багтсан бол/.

5.3.3 Баталгаажуулалтын схемээс хамааруулан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн байдалд дүн шинжилгээ хийх явцад чанарын менежментийн тогтолцооны баталгаажуулалтын үр дүнг харгалзан үзнэ.

5.3.4 Тухайн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл нь стандарт, норматив техникийн баримт бичигт тогтоосон шаардлагыг бүрэн хангасныг холбогдох баримт бичигт үндэслэн харьцуулах аргаар үнэн зөв нотолж үнэлэх:

- Зохион бүтээлт, загварын туршилтын баримтжуулалт
- Чанарын дотоод хяналт
- Бүтээгдэхүүний технологийн хяналт
- Түүхий эдийн хяналт /гарал үүсэл, сорилт, хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлт
- Хэмжих хэрэгсэл, тоног төөхөөрөмж, шалгалт тохируулгын хяналт
- Сав баглаа боодол, хаяг шошгын хяналт
- Түүвэр дээж авах;
- Хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн дунд санал асуулга явуулах;

5.3.5 Үйлдвэрлэлийн байдалд хийсэн дүн шинжилгээ, үйлдвэрлэлийн буюу ISO9001, ISO22000 менежментийн тогтолцооны баталгаажуулалтын (хамрах хүрээ) талаарх мэдээллийг бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээнд тусгана.

5.3.6 Үйлдвэрлэлийн үнэлгээгээр үл тохирол илэрсэн тохиолдолд дараах арга хэмжээ авна.

- илэрсэн үл тохирлын цар хүрээг тодорхойлох;
- залруулах арга хэмжээг хэрэгжүүлэх хугацааг тогтоох;
- шаардлагатай тохиолдолд сонирхогч байгууллагуудад уг бүтээгдэхүүнийг ашиглах нь аюултай болох талаар мэдэгдэх;
- залруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;
- залруулсан тухай тайланг Баталгаажуулалтын байгууллагад хүргүүлэх.

5.3.7 Илэрсэн үл тохирлыг бүрэн залруулсны дараа баталгаажуулалтын байгууллага дараах үйл ажиллагааг явуулна. Үүнд:

- залруулсан тухай тайлантай танилцаж магадлах
- сонирхогч талуудад залруулсан тухай мэдээлэх.
- залруулах арга хэмжээг хэрэгжүүлээгүй буюу энэ нь үр нөлөөгүй болсон гэж үзвэл гэрчилгээг олгохгүй.

5.3.8 Баталгаажуулалтын байгууллага нь хүсэлт гаргагчид түүний хүссэн мэдээллийг олон улсын стандартын дагуу өөрийн эрх мэдлийн хүрээнд өгнө.

5.4 Шийдвэр- Баталгаажуулалтын байгууллага нь сорилтын дүн, үйлдвэрлэлийн үнэлгээ, үйлдвэрлэлийн буюу ISO9001, ISO22000 менежментийн тогтолцооны баталгаажуулалт /хэрэв баталгаажуулалтын схемд орсон бол/, бүтээгдэхүүний тохирлын тухай бусад баримт бичигт дүн шинжилгээ хийсний дараа тухайн бүтээгдэхүүн нь тогтоосон шаардлагад тохирч байгаа эсэхийг үнэлнэ. Энэхүү үнэлгээний үр дүнг шинжээчийн дүгнэлтэд тусгана. Шинжээч дүгнэлтийг Баталгаажуулалтын зөвлөлд танилцуулж, тохирлын гэрчилгээ /цаашид Гэрчилгээ гэх/, аюулгүйн тэмдэг олгох, сунгах, татгалзах тухай шийдвэрийг гаргуулна.

5.5 Гэрчилгээ олгох, бүртгэх

5.5.1 Баталгаажуулалтын байгууллагын ажилтан гэрчилгээг бичиж, бүртгэнэ. Гэрчилгээ нь бүртгэлийн дугаартай бол хүчинтэй байна.

5.5.2 Гэрчилгээнд баталгаажуулалтын схемийн дагуу баталгаажуулалт явуулахад үндэслэсэн баримт бичгүүдийг тусгасан байна.

5.5.3 Хэрэв агуулгыг дэлгэрэнгүй бичих шаардлагатай бол түүнд хамаарах тодорхой бүтээгдэхүүний жагсаалтыг гэрчилгээнд хавсаргаж болно.

5.5.4 Бүтээгдэхүүний тохирлын үнэлгээний үр дүн сөрөг гарсан тохиолдолд баталгаажуулалтын байгууллага нь гэрчилгээ олгохоос татгалзсан тухай шийдвэрийг хүсэлт гаргагчид мэдэгдэнэ. /Энэ тохиолдолд баталгаажуулалтын гэрээг дүгнэж баримтжуулна/.

5.5.5 Гэрчилгээний хүчинтэй хугацааг тухайн бүтээгдэхүүний зохион бүтээлт боловсруулалт, үйлдвэрлэл, үйлчилгээний тогтвортой байдал, норматив техникийн баримт бичгийн хүчинтэй хугацаа, ISO9001, ISO22000 менежментийн тогтолцооны баталгаажуулалтын хүчинтэй хугацаа /хэрэв баталгаажуулалтын схемд орсон бол/ зэргийг харгалзан баталгаажуулалтын байгууллага гурав хүртэл жилийн хугацаагаар тогтооно.

5.5.6 Бүтээгдэхүүний зохион бүтээлт эсвэл үйлдвэрлэлийн технологи болон норматив техникийн баримт бичгийн шаардлагад тохирох байдалд нөлөөлөхүйц өөрчлөлтийг хийвэл хүсэлт гаргагч нь энэ тухай гэрчилгээ олгосон байгууллагад урьдчилан мэдээлнэ. Үүний дагуу баталгаажуулалтын байгууллага нь уг бүтээгдэхүүнд сорилтыг шинээр явуулах, үйлдвэрлэлийг нь дахин үнэлэх талаар шийдвэр гаргана.

5.5.7 Энэ журмын 1.2.1-д заагдсан баталгаажуулалтад хамрагдаж гэрчилгээжсэн бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ, аюулгүйн тэмдэг хэрэглэх эрх олгоно.

5.6 Магадлах хяналт- Баталгаажуулсан бүтээгдэхүүнд магадлах хяналтыг баталгаажуулалтын схемд багтсан тохиолдолд явуулна.

5.6.1 Бүтээгдэхүүний үзүүлж болох болзошгүй хохирлын зэрэг, үйлдвэрлэлийн тогтвортой байдал, үйлдвэрлэлийн хэмжээ, ISO9001, ISO22000 менежментийн тогтолцоотой эсэх, зэргийг шалгуур болгож магадлах хяналтын давтамж ба хамрах хүрээг тогтооно.

5.6.2 Магадлах хяналтыг тохирлын үнэлгээнд хамрагдаж гэрчилгээжсэн аюулгүйн тэмдэг хэрэглэх эрхтэй байгууллагуудад гэрээний дагуу магадлах хяналт явуулна.

5.6.3 Магадлах хяналт нь дараах үйл ажиллагаанаас бүрдэнэ. Үүнд:

- баталгаажуулсан бүтээгдэхүүний талаар ирж байгаа мэдээлэлд дүн шинжилгээ хийх;
- хяналт явуулах ажлын хэсэг байгуулах;
- бүтээгдэхүүнийг сорилт туршилтад хамруулж түүний үр дүнд дүн шинжилгээ хийх;
- хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн дунд санал асуулга явуулах;

- хяналтын дүнг нэгтгэн, шийдвэр гаргах.

5.6.4 Магадлах хяналтын үр дүнг баримтжуулна. Баримтжуулсан мэдээллийн эх хувийг баталгаажуулалтын байгууллагад хадгална. Хувийг хүсэлт гаргагчид болон магадлах хяналтад оролцсон байгууллагуудад хүргүүлнэ.

5.6.5 Магадлах хяналтын үр дүнгийн дагуу дараах тохиолдолд гэрчилгээ, аюулгүйн тэмдэг хэрэглэх эрхийг түдгэлзүүлэх эсвэл хүчингүй болгоно. Үүнд:

- холбогдох норматив баримт бичгийн шаардлагад нийцэхгүй байх;
- хэрэглэгчийг төөрөгдүүлсэн тэмдэг тэмдэглэгээ хэрэглэх;
- Аюулгүйн тэмдгийг буруу хэрэглэх;
- хаяг шошго холбогдох стандартын шаардлага хангахгүй байх;
- бүтээгдэхүүний буюу сорилтын аргын норматив баримт бичигт өөрчлөлт орох;
- бүтээгдэхүүний бүтээц, бүрдэлд өөрчлөлт орох;
- үйлдвэрлэлийн зохион байгуулалт, технологийн горимд өөрчлөлт орох;
- Технологийн горим, хяналт болон сорилтын арга, чанар хангах тогтолцоонд тавих шаардлага өөрчлөгдсөн (эсвэл биелдэггүй), энэ нь бүтээгдэхүүний баталгаажуулалтын шаардлагад үл тохирох байдалд хүргэх нөхцөл бүрдэх.

5.6.6 Хүсэлт гаргагч нь баталгаажуулалтын байгууллагатай зөвшилцөж, тогтоосон хугацаанд залруулах арга хэмжээ авч илэрсэн үл тохирлыг арилгаж, стандартын шаардлагад тохирсныг баталж чадах тохиолдолд дахин шинжилгээ хийлгүйгээр түдгэлзүүлэх шийдвэрийг хүчингүй болгоно. Залруулсан арга хэмжээ нь шаардлагад нийцэхгүй тохиолдолд гэрчилгээ, аюулгүйн тэмдэг хэрэглэх эрхийг хүчингүй болгоно.

Гэрчилгээг түдгэлзүүлсэн, эсвэл хүчингүй болгосон тухай шийдвэрийг хүсэлт гаргагч, хэрэглэгчид, Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, болон бусад сонирхогч талуудад мэдээлнэ.

Зургаа. Сайн дурын баталгаажуулалт

6.1 Энэ журмын 1.2.2-д заагдсан баталгаажуулалтад хамрагдах бүтээгдэхүүнийг хүсэлт гаргагчийн хүсэлтээр буюу сайн дурын үндсэн дээр баталгаажуулалтад хамруулна.

6.2 Сайн дурын баталгаажуулалтад бүтээгдэхүүний тохирлыг хүсэлт гаргагчийн заасан норматив баримт бичгүүдээр тогтоосон шаардлагыг хангасныг үнэлж тогтооно. Дээрх норматив техникийн баримт бичигт тухайн бүтээгдэхүүнд хамааралтай Монгол улсад мөрдөх норматив баримт бичигт заасан аюулгүй байдлын шаардлагуудыг тусгасан байх шаардлагатай.

6.3 Сайн дурын баталгаажуулалтыг заавал баталгаажуулалтад хамрагдах бүтээгдэхүүний баталгаажуулалтын схемийн дагуу явуулна. Тохирлын үнэлгээнд хамрагдаж шаардлага хангасан тохиолдолд тохирлын гэрчилгээ олгоно.

Долоо. Баталгаажуулалтын схемийг ашиглах

7.1 Баталгаажуулалтын 1, 2 дугаар схемийг цуварлаар үйлдвэрлэх бүтээгдэхүүнийг, 3, 4 дүгээр схемийг парт бүтээгдэхүүнийг, 5, 6-р схемийг үйлчилгээг баталгаажуулахад тус тус ашиглана.

7.2 7, 8 дугаар схемийг дараах тохиолдолд ашиглах нь зүйтэй:

7, 8 дугаар схемийг борлуулалтын тоо хэмжээг нь урьдчилан тохирч тогтоосон бөгөөд үйлдвэрлэгдэн гарсан, богино хугацааны туршид салангид партаар нийлүүлэх бүтээгдэхүүнийг баталгаажуулахад (богино хугацааны гэрээт экспортын бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн хэмжээ нь хязгаарлагдмал дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүн)-ийг баталгаажуулахад ашиглана.

7.3 8 дугаар схемийг урт хугацааны гэрээгээр, эсвэл байнга үйлдвэрлэгддэг олон нэр төрлийн парт бүтээгдэхүүнийг тодорхой хугацаагаар байгуулсан гэрээгээр тогтмол нийлүүлэх экспорт, импортын бүтээгдэхүүнийг баталгаажуулахад ашиглана.

7.4 Мөн 3 дугаар схемийг дараах бүтээгдэхүүнийг баталгаажуулахад ашиглаж болно. Үүнд:

- сорилтын болон дээжийн бодит хэмжээ нь бүтээгдэхүүнийг бодитойгоор үнэлэхэд хүрэлцээгүй;
- үйлдвэрлэлийн технологийн дамжлага нь гадаад хүчин зүйлд мэдрэмтгий;
- үйлдвэрлэгдэж байгаа бүтээгдэхүүний шинж чанарын тогтвортой байдалд тавих шаардлага өндөр;
- бүтээгдэхүүний хэрэглээнд тохирох хугацаа нь итгэмжлэгдсэн лабораторид сорилт зохион байгуулан явуулах хугацаанаас бага;
- бүтээгдэхүүний хувилбар байнга солигддог онцлогтой;
- зөвхөн хэрэглэгч дээр очиж суурилсны дараа турших боломжтой.

7.5 Тухайн бүтээгдэхүүнийг баталгаажуулахад шаардагдах бүх үзүүлэлт нь шаардлагад тохирсныг хянах сорилтын тогтолцоог хүсэлт гаргагч өөртөө бүрдүүлсэн бөгөөд энэ нь тохирлын болон менежментийн тогтолцоонд явуулсан үнэлгээний дүгнэлтээр батлагдсан хүсэлт гаргагчийн бүтээгдэхүүнд 1-4 дүгээр схемийг сонгон ашиглаж болно.

7.6 7, 8 дугаар схемийг үйлдвэрлэл буюу борлуулалтын нэг удаагийн шинжтэй бүтээгдэхүүн парт, эсвэл нэгж бүтээгдэхүүнд ашиглавал зохино.

7.7 9 дүгээр схемийг тогтоосон шаардлагад тохирсныг батласан дагалдах баримт бичиг бүхий нийлүүлэгчийн мэдэгдлийг баталгаажуулахад ашиглана. Хүсэлт гаргагч "Нийлүүлэгчийн мэдэгдлийг гаргах, бүртгэх журам"-д тавигдах шаардлагыг хангасан байна.

7.8 7, 8 дугаар схемүүдийн дагуу заавал баталгаажуулалт явуулахад хэрэв хүсэлт гаргагч чанарын менежментийн тогтолцооны буюу үйлдвэрлэлийн тохирлын гэрчилгээ байгаа бол эдгээрийг дахин хийх шаардлагагүй.

7.9 Дээр дурьдсан баталгаажуулалтын схемүүдийг тухайн нэг төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, эргэлт ба ашиглалтын онцлогийг харгалзан баталгаажуулалтын журмаар тогтоодог.

7.10 Техникийн зохицуулалттай бүтээгдэхүүний тохирлыг баталгаажуулахдаа схемийн төрлийг эш татан техникийн зохицуулалтын шаардлагын дагуу үнэлгээ явуулна.

Найм. Баталгаажуулалтын схемд нэмэлт мэдээллийг ашиглах нь

8.1 Хэрэв баталгаажуулалтын схемийн нийтлэг журамд харшлахгүй бол, баталгаажуулалтын схемээр тухайн баталгаажуулалтын хүрээнээс гадуур хүсэлт гаргагчийн хүлээн авсан баримт бичгийг нотолгоо болгон ашиглаж болно. Эдгээр нотолгоо нь баталгаажуулалтын үед хийх шалгалтын хэмжээг багасгах үндэс болж болно.

8.2 Нэмэлт баримт бичгийг ашиглаж үнэлгээ хийхдээ бүтээгдэхүүний өвөрмөц онцлог, түүний аюулгүйн зэрэглэл, бүтээгдэхүүний үйлдвэрлэх хугацаа болон хэмжээ, үйлдвэрлэлийн тогтвортой байдал, баталгаажуулж буй бүтээгдэхүүний чанарт хамаарах үйлдвэрийн нэр хүнд, бүтээгдэхүүний бүрдэл хэсгүүд, материалын чанар, тухайн үйлдвэрт хөндлөнгийн байгууллагуудаас итгэл үзүүлсэн байдал зэргийг харгалзан үзнэ.


8.3 Баталгаажуулж буй бүтээгдэхүүний төрлөөс хамааруулж дараах нэмэлт баримт бичгийг ашиглана. Үүнд:

- сорилт туршилтын дүн /хүлээн авалтын, тогтмол, хяналтын г.м /;
- галын аюулгүй байдлын дүгнэлт;
- Мэргэжлийн байгууллагаас гаргасанхөдөлмөрийн нөхцөл, байгаль орчны үнэлгээ /ерөнхий болон нарийвчилсан дүгнэлт/ гэх мэт
- бараа материал, сав баглаа боодлын тухай нийлүүлэгчийн мэдэгдэл;
- агрохимийн албанаас олгосон тухайн талбайн паспортууд газрын хөрсний чанарын гэрчилгээ;
- химийн бодис хэрэглэсэн тухай ургамал хамгаалах бүсийн болон агрохимийн албаны дүгнэлт /бордоо, пестицид, ургалтыг түргэсгэгч, биобэлдмэл, мелиорантууд г.м/;
- хөл хорьсон газарт ажиллагаа явуулж буй тохиолдолд ургамал хорио цээрийн байгууллагын дүгнэлт;
- мал эмнэлгийн гэрчилгээ;
- хүсэлт гаргагчийн чанарын менежментийн тогтолцоо, бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ /гадаад улсын/;
- гарал үүслийн гэрчилгээ;
- гадаад улсын итгэмжлэдсэн сорилтын лабораторийн дүн;
- хүсэлт гаргагчаасгаргасан техникийн баримт бичиг /зохион бүтээлт, технологийн заавар г.м/

Дээр дурдсан баримт бичгээс гадна баталгаажуулалтын байгууллагын шийдвэрээр мэдээллийн үнэн зөв байдалд эргэлзээ төрөхөөргүй бусад баримт бичгийг ашиглаж болно.

---ooOoo--

БҮТЭЭГДЭХҮҮН БАТАЛГААЖУУЛАЛТЫН СХЕМИЙН ҮЙЛ ЯВЦЫН ЗУРАГЛАЛ



Монгол улсад бүтэээгдэхүүн, ажил үйлчилгээний баталгаажуулалтыг схемийн дагуу явуулах нийтлэг журмын хавсралт 2

Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний баталгаажуулалтын схемийн бүрэлдэхүүн

Схемийн дугаар	Итгэмжлэгдсэн сорилтын лабораториор шинжлүүлэх болон тохирлыг тодорхойлох бусад арга	Үйлдвэрлэлийн үнэлгээ	Үйлдвэрийн дотоод хяналт	Баталгаажуулсан бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний магадлах хяналт
Схем 1	Итгэмжлэгдсэн лабораториор сорилтын дээжийг тодорхой нөхцөлтэйгөөр шинжлүүлэх	Үйлдвэрлэлийн байдалд дүн шинжилгээ хийх	Үйлдвэрлэлийн байдалд дүн шинжилгээ хийх	Үйлдвэрлэгч буюу зах зээлээс дээж авч сорилт явуулах
Схем 2	Итгэмжлэгдсэн лабораториор сорилтын дээжийг тодорхой нөхцөлтэйгөөр шинжлүүлэх	Үйлдвэрлэлийн байдалд дүн шинжилгээ хийх	Үйлдвэрлэлийн байдалд дүн шинжилгээ хийх	Үйлдвэрлэгч буюу зах зээлээс дээж авч сорилт явуулах
Схем 3	Итгэмжлэгдсэн лабораториор сорилтын дээжийг тодорхой нөхцөлтэйгөөр шинжлүүлэх	Үйлдвэрлэлийн байдалд дүн шинжилгээ хийх	Үйлдвэрлэлийн байдалд дүн шинжилгээ хийх	-
Схем 4	Итгэмжлэгдсэн лабораториор сорилтын дээжийг тодорхой нөхцөлтэйгөөр шинжлүүлэх	Үйлдвэрлэлийн байдалд дүн шинжилгээ хийх	Үйлдвэрлэлийн байдалд дүн шинжилгээ хийх	-
Схем 5	-	Үйлдвэрлэлийн байдалд дүн шинжилгээ хийх	-	Хэрэглэгч үйлчлүүлэгчийн санал хүсэлтэд дүн шинжилгээ хийнэ.
Схем 6	-	Үйлдвэрлэлийн байдалд дүн шинжилгээ хийх	Үйлдвэрлэлийн байдалд дүн шинжилгээ хийх	
Схем 7	Итгэмжлэгдсэн лабораториор сорилтын дээжийг тодорхой нөхцөлтэйгөөр шинжлүүлэх өргөдлийг хавсаргасан баримт бичгийн хамтаар хянан үзэх	-	-	-
Схем 8	Итгэмжлэгдсэн лабораториор сорилтын дээжийг тодорхой нөхцөлтэйгөөр шинжлүүлэх Өргөдлийг хавсаргасан баримт бичгийн хамтаар хянан үзэх	-	-	-
Схем 9	Нийлүүлэгчийн мэдэгдэл хүсэх өргөдлийг хавсаргасан баримт бичгийн хамтаар хянан үзэх	-	-	-

е. Залруулах үйл ажиллагааны тайланг үндэслэж үл тохиролыг хаах	X	X	X	X	X	X	-	-	-
f. Тохирлын үнэлгээний тайлан бэлтгэх	X	X	X	X	X	X	-	-	-
4 Баталгаажуулалтын шийдвэр гаргах									
Баталгаажуулалтын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэх, шийдвэр гаргуулах	X	X	X	X	X	X	-	-	X
Гэрчилгээжүүлэх	X	X	X	X	X	X	-	-	X
5 Магадлах хяналт									
Магадлах үнэлгээ хийх	X	-	-	-	-	-	-	-	-
Зах зээлээс дээж авах	-	-	-	-	-	-	-	-	-
Бүтээгдэхүүний дээжийг тодорхой давтамжтайгаар үйлдвэрлэл болон зах зээл дээрээс авах	-	-	-	-	-	-	-	-	-
Бүтээгдэхүүний дээжийг үйлдвэрлэл дээрээс авах	-	-	-	-	-	-	-	-	-